

ДеФакто **ТОЙМ**

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН
ЦАЛИНГ НЭМНЭ

АМЬЖИРГААНЫ БАТАЛГААЖИХ
ДООД ТҮВШИН ШИНЭЧЛЭГДЛЭЭ

СЭТГҮҮЛЧДИЙН НЭГДСЭН ЭВЛЭЛИЙН
17 ДУГААР ИХ ХУРАЛ БОЛЛОО

ҮЙЛДВЭРЖИЛТИЙГ ДЭМЖИХ
21:100 ХӨТӨЛБӨР БАТЛАГДЛАА

VI НҮҮРТ

ДеФакто **ЯРИЛЦАГА**

Р.ЭНХТҮВШИН

АШУУИС-ийн Сэтгэцийн
эрүүл мэндийн тэнхимийн багш

**АЗИЙН ОРНУУДАД
СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ШИНЖ
ЧАНАРТАЙГААР АМИА
ЕГҮҮТГЭХ НЬ ИХ БАЙДАГ**

IV НҮҮРТ

ДеФакто **НИЙТЛЭЛ**

ЗЭЭЛИЙН ХҮҮГ

Хязгаарлах тухайг

Монгол Улсын Их Хурал “Банкны зээлийн хүүгийн хувийн дээд хэмжээг тогтоох тухай” хуулийн төслийг хэлэлцэж байна. Зээлийн хүү өндөр байгаа нь бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг өсгөж, аж ахуйн нэгжүүдийг дампуурахад хүргэж, бизнес хийх эрмэлзлэлийг мохоож байна.

II НҮҮРТ

The Defacto Gazette

МЭДЭЭЛНЭ

ЗОРИГЖУУЛНА

МЭДЭЛЖҮҮЛНЭ

Лхагва, 2018.02.14, №34

УЛС ТӨР, ЭДИЙН ЗАСГИЙН ДҮН ШИНЖИЛГЭЭНИЙ ХАРААТ БУС, БИЕ ДААСАН ДОЛОО ХОНОГ ТУТМЫН СОНИН

www.defacto.mn

ЗЭЭЛИЙН ХҮҮГ

Хязгаарлах тухайг





№418

Дамбадаржаагийн **ЖАРГАЛСАЙХАН**

Долоо хоног бүрийн нийтлэл,
<http://jargaldefacto.com/category/23>

ЗЭЭЛИЙН ХҮҮГ

Хязгаарлах тухайг

Монгол Улсын Их Хурал “Банкны зээлийн хүүгийн хувийн дээд хэмжээг тогтоох тухай” хуулийн төслийг хэлэлцэж байна. Зээлийн хүү өндөр байгаа нь бүтээгдэхүүн, үйлчилгээний өртгийг өсгөж, аж ахуйн нэгжүүдийг дампуурахад хүргэж, бизнес хийх эрмэлзлэлийг мохоож байна.

Нийгмийн өмнө тулгамдаад буй энэ чухал асуудлаар

ээлжит “**Дефакто мэтгэлцээн**”-ийг МҮОНТелевизээр өнгөрсөн долоо хоногт зохион байгуулав. Зээлийн хүүд хуулиар дээд хязгаар тогтоохыг дэмжиж санхүүч Д.Ангар, няцааж эдийн засагч С.Болд нар оролцов. Тэдний судалгаа, дүгнэлттэй тайлбар, мэтгэлцээнийг хураангуйлан багцлан уншигчиддаа доор хүргэж байна.

ЗЭЭЛИЙН ХҮҮД ХУУЛИАР ДЭЭД ХЯЗГААР ТОГТООХ НЬ ЗӨВ

Санхүүгийн зах зээл нь эдийн засагт санхүүгийн хуримтлалтай хэсгийг хэрэгцээтэй хэсэг буюу аж ахуйн нэгжүүдтэй холбож зуучлах үүрэгтэй. Энэ үүргийг өнгөрсөн 27 жилд зөвхөн арилжааны банкууд гүйцэтгэж ирсэн боловч зуучлалын үнэ хэтэрхий өндөр байна. Тиймээс энэ үнийг аж ахуйн нэгжүүдэд хүртээмжтэй, үйл ажиллагаагаа явуулахад нь өгөөжтэй байх үүднээс зээлийн хүүгийн дээд хязгаарыг хуулиар тогтоох учиртай.

Манайх банк, ББСБ, хадгаламж зээлийн хоршоо, хөрөнгийн биржийн хууль журам тогтолцоог бүгдийг нь гадаадын улс орнуудаас хуулбарласан атлаа, өндөр хөгжилтэй зах зээлийн 80-аад оронд хэрэгжүүлсэн зээлийн хүүг хуулиар хязгаарлахыг нь орхисон байна. Үр дүнд нь банкууд бизнесийг дэмжих биш, тэдний мөнгийг хүүлдэг хэрэгсэл болов.

Төрийн бодлого банкуудын лоббигоор явагдаж, зөвхөн тэдэнд үйлчилж ирсэн тул хөрөнгийн зах

зээл хөгжсөнгүй. Хөрөнгийн бирж, даатгалын салбар хөгжөөгүй тул санхүүгийн зуучлал зөвхөн 14 банкаар дагнан явагдаж байна. Банкууд нь хуримтлалтай хүмүүсийн [МБ-ны мэдээгээр 100 сая төгрөгөөс [40 мянган ам. дол] дээш хадгаламжтай хүн улсад 9900 байна] хойноос уралдан өрсөлдөж хадгаламжийн хүүг хэт өндөр хөөргөдсөөр байна. Үүний хор уршгийг нь бизнес эрхлэгчид, аж ахуйн нэгжүүд амсаж, өндөр хүүтэй зээл авахаас өөр сонголтгүй болжээ. Өндөр хүүтэй зээлээс болоод манайд үйлдвэрлэл бий болохгүй, эдийн засаг нь хөгжихгүй байна.

Монгол дэлхийд хамгийн өндөр зээлийн хүүтэй 10 орны нэг болжээ. Хэрэв мөнгө хүүлэлтийн эсрэг хууль гаргаж банкны зээл 18-20 хувиас бага болчихвол банкууд хадгаламжийн хүүгээ бууруулна. Зээлээ 18 хувийн хүүтэй гаргахын тулд хадгаламжаа 14 хувьтай татаж буй нь буурч 9 болно гэсэн үг. Энэ нь ч гэсэн бусад улсын жишгээр маш өндөр хадгаламжийн хүү.

ЗЭЭЛИЙН ХҮҮД ХУУЛИАР ДЭЭД ХЯЗГААР ТОГТООХ НЬ БУРУУ

Зээлийн хүүг хязгаарлах асуудал бол маш дээр үеийн хуучин сэдэв. Тийм хууль гаргаж, төсөөтэй механизм хэрэгжүүлсэн бүх улс орнууд хүлээж байснаасаа эсрэг үр дагавар амссан байдаг.

Зээлийн хүү бол эдийн засгийн тусгал, шинж тэмдэг нь юм. Асуудлын шалтгаан нь зээлийн хүүдээ биш, эдийн засгийн бүтцийн сууриндаа юм. Хүүг бууруулахын тулд суурь асуудалтайгаа ноцолдох ёстой. Хэрвээ тодорхой түвшинд эдийн засагт хуримтлал бий болбол, тэр нь аль болох найдвартай, тогтвортой өгөөжтэй салбар руу явдаг жамтай. Өнөөдөр монголын банкны систем санхүүгийн бусад



зуучлалаас илүү хурдан хөгжсөн нь банкуудын буруу биш юм.

МУ-ын зээлжих зэрэглэлийг гадаадын рейтингийн агентлагууд сүүлийн хориод жилд САА1-ээс В1-ийн хооронд буюу 100 оноогоор тооцвол 20-40-ийн хооронд л үнэлж байжээ. Энэ хугацаанд эдийн засагт гадаадын шууд хөрөнгө оруулалтаар (ГШХО) 15 тэрбум ам. доллар орж ирсэн байна. Харин энэ хөрөнгө эдийн засагт шингэж үлдэв үү, эсвэл гадагшлав уу гэдгийн ерөнхий индикатор нь гадаад төлбөрийн тэнцэл (ГТТ) гэж болно. Гэтэл энэ хориод жилд ГТТ 1.1 тэрбум ам. долларын л ашигтай байж. Энэ нь орж ирсэн валют монголд шингэдэггүй, угаагдаад гарсан мэт загвартай байжээ.

Үүнээс гадна дээрх хугацааны ихэнх жилүүдэд жилийн дундаж инфляци 10 хувь байжээ. Тэгээд эдийн засаг энэ хугацаанд хагас их наяд төгрөгөөс 27 их наяд болж тэлсэн байна. Банкны системийн олгосон зээлийн өрийн үлдэгдэл 1 их наядаас 16

их наяд төгрөг болжээ. Зээлийн хүү хорин жилийн өмнө 48, арван жилийн өмнө 28, харин одоо бол 19 хувь болжээ. Энэ бүх статистик 14 банк чинь ямартай ч гэсэн санхүүгийн зуучлалаа тодорхой түвшинд гүйцэтгэж ирснийг нотолж байгаа юм.

Хуулиар зах зээлийн хүү тогтоохоор эрсдэл бага, барьцаа хөрөнгө, баталгаа сайтай зээлдэгчид зээл олгох, харин эрсдлийн түвшин арай өндөр зээлдэгчид, бичил, жижиг болон дунд бизнест зээл олгохгүй байх механизм руу аяндаа шилжүүлдэг. Энэ нь зээлийн нийлүүлэлтэд сөргөөр нөлөөлж, санхүүгийн зуучлал, санхүүгийн нэвтрэлт зэрэг үзүүлэлтүүд мууддаг. Латин Америк, Африк болон Азийн олон орны жишээ, судалгаагаар зээлийн хүү богино хугацаанд буураад байгаа юм шиг боловч, урт хугацаанд эсрэгээрээ өсөх зүй тогтол руу орсон байдаг. Үүнийг Монголбанкнаас гадна Азийн Хөгжлийн Банк (АХБ), Дэлхийн Банк (ДБ) зэрэг олон улсын байгууллагуудын судалгаанууд нотолдог.

ХАРИЛЦАН НЯЦААЛТ

Дэмжигч тал: Монголбанк банкуудын зээлийн дундаж хүү 18-20 хувь гэдэг. Гэтэл жижиг дунд ААН-үүдийн зээл сарын 2-2.5 хувь буюу, жилээр бол 30-36 хувь байна. Ийм өндөр хүүтэй зээлээр үйлдвэрлэл явуулах боломжгүй. Тийм ч учраас манай эдийн засаг ямар ч үйлдвэрлэл, бүтээн байгуулалтгүй, хэрэглээнд суурилсан эдийн засаг болчихоод байна.

Монголын санхүүгийн зах зээлд сүүлийн 27 жилд дутагдсан зүйл нь өрсөлдөөн юм. Одоогоор дэлхий дээр гадны банкгүй хоёрхон улс байгаа нь Хойд Солонгос ба Монгол. Гадны банк орж ирснээр өрсөлдөөн бий болж, хүү буурч, бүтээгдэхүүний чанар сайжирна.

Зээлийн хүүгийн дээд хязгаар тогтоосон 80-аад улсыг авч үзвэл сөргөөсөө эерэг үр дагавар нь их байсан. АНУ-д банкны зээлийн хүү жилийн 8 хувиас хэтрэхгүй байх хуультай. Германд 20, Францад 28 гэх мэт. Япон зээлийн хүү нь хамгийн бага орон. ЗГ-ын бонд нь хасах тал руугаа орсон. Бизнесийн зээл жилийн 1 хувийн хүүтэй. Ипотекийн зээл жилийн хагас хувийн хүүтэй. Гэтэл Япон 1950-60 онуудад дэлхийн хамгийн өндөр зээлийн хүүтэй орон байсан. Хууль бус бүлэглэл нь өндөр хүүтэй зээлтэй холбогддог байсан.

Японы парламентаас 1956 онд шинэ бодлогоор хүүлэлтийн эсрэг хууль гаргасан. Хугацааныхаа явцад 30 байснаас буулгасаар өнөөдөр иргэний, хуулийн аль ч хэлцэл жилийн 20 хувиас хэтрэхгүй хуультай. Түүнээс биш банкууд хэзээ ч ашгаа бууруулж хүүгээ буулгахгүй.

Няцаагч тал: Би Монголбанкинд ажиллаж байсан хүний хувьд тус байгууллагыг худлаа статистик гаргадаг гэж бодохгүй байна. Хэрэв тийм бол

монголын эдийн засгийн бүх тоо худлаа болж хувирна. Өнөөдөр 36 хувийн хүүтэй зээл олгодог банк байхгүй. Та 20 жилийн өмнөх тоо ярьж байна. Банкны системийн хэмжээнд жигнэсэн дундаж зээлийн хүү 19-19.5 хувьтай байгаа. Хэрэглээний зээл, бичил зээл гэвэл өөр байх. Зарим банкууд бүх зээлийн хүүгээ жилийн 24 хувь буюу сарын 2 хувиас хэтрэхгүй байхаар дотоод журмаараа зохицуулж байна.

Хуулиар хүүг тогтооход эерэг үр дүн гэж байхгүй. Харин ч МУ-ын хувьд асар том ухралт болно. Иймэрхүү хууль тогтоомж, бизнесийн орчинтой оронд гадаадын хөрөнгө оруулалт хийгдэхгүй, бизнес явагдахгүй. Үндсэн асуудалтайгаа биш, үр дагавартай ноцолдоод байгаа улс яаж харагдах вэ?

Санхүүгийн эх үүсвэр хомс, эдийн засагт мөнгө дутагдалтай, зээлийн олдоц маш муу байгаа нь үнэн. Яагаад гэвэл өнгөрсөн 20 жилийн 13-т нь эдийн засаг ямар нэгэн байдлаар хямралтай, нөлөө нь арилаагүй, хэвийн бус бизнесийн орчинтой байв.

АНУ, Япон, Франц, Германд энэ хуулийг хэрэгжүүлж үзсэн. АНУ-д цалингийн зээлийн хүү өндөр байсан. Хүү богино хугацаанд буурч байсан ч, урт хугацаанд тогтоосон хязгаартаа хурдан хүрсэн. АНУ, Японд хууль бус зээл, иргэд хоорондын зээл нэмэгдэж, далд хэлбэр рүүгээ шилжсэн.

Үргэлжлэл бий

2018.02.14



Р.ЭНХТҮВШИН

АШУУИС-ийн Сэтгэцийн эрүүл мэндийн тэнхимийн багш

АЗИЙН ОРНУУДАД СЭТГЭЛ ХӨДЛӨЛИЙН ШИНЖ ЧАНАРТАЙГААР АМИА ЕГҮҮТГЭХ НЬ ИХ БАЙДАГ

Рэгээдмаагийн Энхтүвшин нь 2014 онд Анагаах ухааны магистрын зэргээ хамгаалсан ба сэтгэл заслын эмчийн нарийн мэргэжлээр суралцжээ. 2008 оноос хойш сэтгэцийн эрүүл мэндийн эмчээр тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд 2014 оноос багшилж эхэлжээ. Мөн 2017 оноос эхлэн Сэтгэцийн Эрүүл Мэндийн Үндэсний Төвд эмчээр ажиллаж байна.

Д.Ж: Амиа хорлож байгаа хүмүүсийн тоо улсын нийт хүн амтай харьцуулахад ердийн бус их байна. Үүнийг олон улсын судалгаанууд харуулсан байна гэсэн тэр тухайгаа дэлгэрэнгүй ярьж өгөөч.

Р.Э: Дэлхийн хэмжээнд жилд дунджаар 1 сая хүн буюу 40 секундэд нэг хүн амиа егүүтгэж нас барж байна гэсэн тооцоолол бий. Амиа егүүтгэх гэдэг бол байгалийн жам бусаар тухайн хүн өөрөө өөрийнхөө амийг егүүтгэж байгаа хэлбэр юм. Манайд мөн энэ тоо өссөн хандлага байгаа. Эрүүл мэндийн хөгжлийн төвийн хийсэн судалгаануудаас аваад үзэхэд манай улсад жилд 16000-17000 хүн нас барж байгаагаас амиа егүүтгэж байгаа тохиолдол нь 460-475 хооронд байна. Үүнийг насны бүлгээр нь хуваагаад үзэхэд амиа егүүтгэх нь 15-34 насны ид залуу хүмүүсийн нас баралтын гол шалтгаан болсон нь харагдана. Тэр дундаа 18-29 насныхан дийлэнхийг нь эзэлж байна. Өөрөөр хэлбэл ид боловсорч, оюуны бядаа гаргаж байх ёстой насан дээрээ тэд хорвоогийн мөнх бусыг үзүүлж байгаа нь үнэхээр харамсалтай.

Д.Ж: Энэ тоон үзүүлэлт дэлхийн бусад улс орнуудтай харьцуулахад ямар байна вэ?

Р.Э: Амиа егүүтгэлийг 100 мянган хүнд ноогдох хэмжээгээр авч үздэг бөгөөд 15-аас дээш бол дунджаас дээгүүр буюу анхааралдаа авах ёстой, 20-оос дээш байвал болохоо байлаа гэж үздэг бол 25-аас дээш гарвал үндэсний аюулгүй байдлын хэмжээнд хүрдэг. Манай улсын хувьд 2003 онд хийсэн судалгаагаар 17, 2006 онд 19, 2010 онд 20.2 болсон байдаг. Харин 2017 оны ДЭМБ-аас гаргасан судалгаагаар амиа егүүтгэлийн тоо 28,1 болж дэлхийд 3-рт жагссан байгаа юм.

Д.Ж: 1, 2-р байранд ямар улс орсон бэ?

Р.Э: Нэгдүгээрт Шри Ланка, хоёрдугаарт Гана улс орсон байна лээ. Тэгээд Монгол, дараа нь Казакстан гэх мэтчилэн. Одоогоос 10 жилийн өмнө Өмнөд Солонгос улс 4-р байранд явж байсан бол одоо 10-рт жагсаж байна.

Д.Ж: Тэгэхээр энэ чинь эдийн засгийн асуудал байх нь ээ?

Р.Э: Маш олон төрлийн асуудал байна гэж үзэж байгаа. Нийгэмд болж бүтэхгүй байгаа үзэгдлүүдийг

нийгмийн гаж үзэгдэл гэж нэрлэдэг. Жишээ нь, амиа егүүтгэл, хар тамхины хэрэглээ, архидалт, биеэ үнэлэлт, хүнд ноцтой гэмт хэргүүд гэх мэт. Зарим судлаачид үүнийг социологитой шууд хамааралтай гэж үздэг. Эдгээр гаж үзэгдлүүд зарим үед нийгмийн буруу хууль, шийдвэрүүд гарсан, эдийн засгийн уналтанд орж ажилгүйдэл үүссэнээс болж гарч болно. Амиа егүүтгэлийн тохиолдол ихсэх тусам бидний гаргасан шийдвэр буруу байгаа юм байна, эсвэл эдийн засаг уналттай байна гэдгийг илэрхийлж өгдөг.

Д.Ж: Тэгвэл энэ аюулаас залуучуудыг яаж анхаарах вэ?

Р.Э: Ер нь бол амиа егүүтгэл залуу хүмүүсийн нас баралтын гол шалтгаануудын нэг байдаг юм. Эхлээд осол гэмтэл, дараа нь амиа егүүтгэл ордог. Өндөр хөгжилтэй Европын орнуудад амиа егүүтгэлийн шалтгааныг судалж үзэхэд ихэнх нь сэтгэцийн эмгэгээс болдог юм байна. Үүнд ихэвчлэн сэтгэл гутрал, хоёр туйлтай эмгэг болон мансууруулах бодисын хамааралтай хүмүүс амиа хорлож байна гэсэн. Харин манай улс болон Азийн улсуудад сэтгэцийн эмгэг хэзээ ч гол шалтгаанд ордоггүй юм байна. Ихэвчлэн сэтгэл хөдлөлийн шинж чанартай буюу гэр бүл, стресс болон хайр дурлалын асуудлаас үүдэн амиа егүүтгэх нь их байдаг. Энэ нь илүү өвдөр болмжтой буюу тулгамдаж байгаа асуудалтай хүмүүсийн асуудлаа шийдэж байгаа хэлбэр юм.

Д.Ж: Тэгвэл энэ чинь засаж, залруулж болох ажил байна шүү дээ.

Р.Э: Сэтгэцийн эмгэгтэй хүмүүсийг эмчлэхэд маш урт хугацаанд байнгын хараа хяналттай байх учраас өндөр үнэтэй байдаг. Манайд сэтгэл хөдлөлөөс шалтгаалсан зүйлс их учраас урьдчилан сэргийлэх боломжтой гэж үзэж байгаа. 1997 онд Доржидмаа гуайн хийж байсан судалгаанаас авч үзэхэд HOTLINE систем буюу утсаар зөвлөгөө өгдөг үйлчилгээг улсын хэмжээнд байх ёстой гэсэн боловч өнөөдрийг хүртэл ийм үйлчилгээ гараагүй байна.

Д.Ж: Яагаад хийж болохгүй байгаа юм бэ?

Р.Э: Дэмжлэг байхгүй, эдийн засгийн бололцоогүйгээс болдог байх. Одоогийн байдлаар хамгийн боломжтой

шийдэл нь өсвөр үеийнхэнд зориулсан сэтгэл зүйн зөвлөгөө өгөх төвийг хаа сайгүй нээх хэрэгтэй. Ерөнхий боловсрол болон их, дээд сургуулиудад орон тооны сэтгэл зүйч заавал байх хэрэгтэй. АШУҮИС дээр 2016 оны 12-р сард оюутнуудад үйлчилдэг сэтгэл зүйн үнэгүй зөвлөгөө өгөх төв нээсэн нь анхдагч болсон юм. Тус төвөөр нэг жилийн дотор 8 сургуулийн 230 гаруй оюутнууд үйлчлүүлсэн байна. Ингээд 10 гаруй хүнийг амиа егүүтгэх оролдлогоос нь ангигруулж чадсан байгаа юм.

Д.Ж: Өөрийгөө илэрхийлэх учраа олохгүй байгаа хэн ч гэсэн АШУҮИС дээр очоод мэргэжлийн сэтгэл зүйчтэй уулзах боломжтой гэсэн үг үү?

Р.Э: Боломжтой. Гэхдээ хүрч үйлчлэх цаг хомс, маш завгүй байдаг.

Д.Ж: Бид материаллаг зүйлдээ анхаарч хурууныхаа завсраар олон хүний амь насыг “савируулж” алдаж байна. Танд өөр ямар шийдэл байна вэ?

Р.Э: Амиа егүүтгэлийн оролдлого болон нас баралтыг бүртгэдэг системтэй болох хэрэгтэй. Амиа егүүтгэл болон оролдлогыг аль алиныг нь бүртгэдэг байх хэрэгтэй юм л даа. Жишээ нь хэн нэгэн хүн амиа егүүтгэх оролдлого хийгээд гарынхаа шууг зүсээд гэмтлийн эмнэлэгт очлоо гэж бодъё. Гэтэл эмнэлгийн онош нь амиа егүүтгэх оролдлого хийсэн гэж тавигддаггүй, зөвхөн тухайн шархтай нь холбоотой мэдээллийг л бичдэг. Өөрийгөө санаатайгаар гэмтээх оролдлого хийсэн бол төлбөр төлдөг учраас түүнээс зугтаж худлаа ярьдаг. Эрүүл мэндийн салбар дотроо бүх эмнэлэг, цагдаагийн байгууллага болон шүүх эмнэлгийн байгууллагууд бүх тоогоо нэгтгэдэг байх хэрэгтэй. Судалгаануудыг аваад үзэхээр бид бүх амиа егүүтгэсэн тохиолдлыг бүртгэж чадсан уу гэдэг асуудал хүртэл яригдаж байгаа юм.

Д.Ж: Амиа хорлосон хүнийг оршуулах үйл явц ямар байдаг юм бэ? Үүнийг гэмт хэрэг гэж үзэх үү, мөн түүний цаад үр дагавар нь юу байх вэ?

Р.Э: Дээр үед үүнийг гэмт хэрэг гэж үзээд оршуулах газар өгдөггүй байсан тохиолдол бий. Одоо тийм биш бөгөөд байгалийн жамаар мөнх бусыг үзүүлсэн хүнтэй адил оршуулна. Хуулинд ганц заалт байдаг нь зайлшгүй амиа егүүтгэхэд хүргэсэн хүнд тодорхой хэмжээний арга хэмжээ авдаг.

Д.Ж: Урьдчилан сэргийлэх өөр ямар арга хэмжээ авч болох вэ? Бусад орны жишээнээс хуваалцаач.

Р.Э: Энэ асуудлын хувьд хэвлэл, мэдээллийн хэрэгслүүдэд тодорхой хэмжээний хяналт тавьдаг байх ёстой. Өнгөрсөн жил хоёр хүүхэд хөтлөлцөөд өндөр байшин дээрээс үсэрсэн бичлэгийг нь хийгээд олон нийтийн сүлжээнд тавьсан байсан. Ийм төрлийн мэдээллийг цацаж хэзээ ч болдоггүй юм. Яагаад гэвэл

үүн дээр медиа эффект гэдэг юм үүсдэг. Үүний нөлөө нь хэвлэл мэдээллийн хэрэгслээр хүмүүсийн амиа егүүтгэлийг турхирч байгаа хэлбэр гэж үздэг. Зарим нэг сэтгэл зүй нь тогтворгүй байгаа хүмүүс хэвлэл мэдээллийн хэрэгслээр тийм зүйл хараад сэдэл авдаг. Өнгөрсөн жил бид “Цахим ертөнц дэх амиа егүүтгэлийн чиг хандлага”-ыг судлаад үзэхэд хувийн блогуудын 75 хувь нь амиа егүүтгэлтэй холбоотой мэдээлэл бичсэн байгаа юм. Мөн мэдээллийн сайтуудад хүмүүсийн анхаарлыг татахын тулд хурц шийдэлтэй мэдээллүүд явж байгаа. “Амиа егүүтгэлийн гарын авлага” гэсэн гарчигтай нийтлэл бичихсэн байх жишээний. Тухайн нийтлэлийн хамгийн сүүлийн өгүүлбэр нь “амиа егүүтгэсэнээс больсон нь дээр юм биш үү” гэсэн байгааг нь “анти” гэж хармаар, гэвч доор нь бичсэн 160-170 хүний сэтгэгдлийн 87 хувь нь амиа егүүтгэлийг дэмжсэн утгатай байгаа юм. Тэгэхээр бид амиа егүүтгэлийн тухай хэвлэл мэдээллийн хэрэгслээр маш хязгаартай ярьж байх ёстой.

Д.Ж: Хүүхдээ олон нийтийн сүлжээг хэрхэн хэрэглэж байна, ямар группт байгаа вэ гэдгийг эцэг, эх нь заавал мэдэж байх ёстой. Эцэг эхийн анхаарал халамжийн тухай та яриач?

Р.Э: Амиа егүүтгэсэн хүний ойр хавийн 6-аас доошгүй хүн насан туршдаа шархтай явдаг гэж үздэг. Олон нийтийн газар амиа егүүтгэсэн бол хамгийн багадаа 100-аас дээш хүн сэтгэлийн шархтай үлддэг. Зөвхөн түүнийг харсныхаа төлөө сэтгэлийн асар их зовлон шаналалд автдаг. Гэтэл бичлэг хийгээд олон нийтийн сүлжээнд тавьчихаар маш олон хүн цочрол авч байгаа юм. Мөн дээр ярьсан нийгмийн гаж үзэгдэл гэдэг дээр, залуусын дунд далд хэлбэрийн хар тамхи, мансууруулах бодисын хэрэглээ нэмэгджээ. Хамгийн гол нь далд хэлбэрээр явагдаад байна. Үүнийг яаж мэдэж байгаа вэ гэхээр шүүх сэтгэгц, эмгэг судлалын шинжилгээгээр өдөр бүр хар тамхины асуудалтай хүмүүс орж ирж байна. Заримдаа бүр олноороо орж ирэх жишээтэй. Хар тамхи, мансууруулах бодис нь эцэстээ заавал амиа егүүтгэх оролдлогод хүргэж байдаг. Мансууруулах бодис хэрэглэх үед хүний духны төв дарангуйлагдаж өөрийгөө хянах чадваргүй болдог. Хянах чадваргүй болохоор амиа егүүтгэх оролдлогыг их хийдэг. Амиа егүүтгэх оролдлого хийгээд эмнэлэгт ирж байгаа хүмүүсийн 30 хувь нь өмнө нь ямар нэгэн байдлаар оролдлого хийж байсан хүмүүс байдаг. Энэ нь бид тухайн хүмүүст хангалттай тусламж, үйлчилгээ үзүүлээгүйн улмаас тэр хүмүүс давтан ирж байгаа юм.

2018.01.24

Дефакто ярилцлагын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Ярилцлагын бүрэн эхийг

<http://jargaldefacto.com/article/r-enkhtuwshin-enkhtuvshin-regzedmaa> холбоосоор үзнэ үү.

Ангилалдаа анхдагч:

- Их бие. Цэргийн зориулалтын өндөр чанартай хөнгөн цагааны хайлш
- Орчныг бүрэн хянах 360 хэмийн камер болон 4L бартааг тохиргоонд ажиллах хос камер (урд, хойд)
- Тэвшний хаалгыг алсаас нээх удирдлага
- Хийн дэртэй зорчигчийн суудлын бүс

Ангилалдаа шилдэг:

- Хөдөлгүүр: 691нм мушгих хүч 450 морины хүч
- Хамгийн бага бензин зарцуулалт
- Ачих даац: 1.5тн
- Чирэх даац: 3.6тн

Цэргийн зориулалтын өндөр чанартай хөнгөн цагааны хайлшаар хийсэн их бие нь автомашины жинг 226.8 кг-р хөнгөрүүлсэн



Захиалга авч байна. Утас: 7011-3673, 9910-8368, 9910-6507, 9911-8375, 9911-8301 www.waa.mn



ДеФакто **ТОЙМ**

Ням гараг бүр VTV телевизээр 19 цагт гардаг Дефакто тоймын эмхэтгэл: 2018.02.11-ний дугаар

Долоо хоног бүрийн тойм, <http://fargaldefacto.com/category/12>

ТӨРИЙН АЛБАН ХААГЧДЫН ЦАЛИНГ НЭМНЭ

Юуны түрүүнд бид яагаад Олон Улсын Валютын Сангийн хөтөлбөрт хамрагдсан бэ гэдгийг эргэж харах хэрэгтэй. Хөтөлбөрт хамрагдсаныхаа хүчээр “хямдхан” том зээл авч макро эдийн засгийн үзүүлэлт сайн гарч, төсвийн алдагдал багассан. Алдагдлаа багасгахын тулд төсвийн орлогоосоо давсан хөрөнгийг зардалд биш харин бүтээн байгуулахад зориулах ёстой. Гэтэл зардал гаргах гэж байгаа мөртлөө хөтөлбөр амжилттай хэрэгжиж байгаа гэх нь тийм айхтар гайхуулаад байх үнэлэлт биш гэж үзэж байна.

Монгол улсын нийт ажиллах хүч буюу сая гаруй хүн нь цалин авдаг. Түүний 200 мянгад нь буюу 20 хувийнх нь цалинг нэмэхээр инфляцид нөлөөлөх нь аргагүй юм. Харин Монголбанкнаас үзэж байгаа 6.4 хувь нь оны эцэст 8 хувь байтугай болох болов уу гэж би таамаглаж байна. Ямар ч байсан Монголбанк Засгийн газраас хараат бус учраас энэ цалин нэмэх асуудалд байр сууриа илэрхийлэх ёстой.

Төрийн албан хаагчийн цалин бизнесийн байгууллагуудад зайлшгүй нөлөөлнө. Учир нь цалин гэдэг бол хөдөлмөрийн бүтээмжийг цалин хөлстэй нь уялдуулсан байхыг хэлдэг. Хувийн салбарт үүнийг уялдуулдаг бол төр уялдуулж чадахгүй байгаа юм. Ийнхүү төр хүмүүсийн хөдөлмөрийн бүтээмжийг яаж хэмжиж байгаа нь тодорхойгүйгээр нэмээд, цалинг уялдуулахгүй байхаар хүмүүсийн төрийн байгууллагад орох хүсэл улам нэмэгдэж, хувийн салбарт ч мөн адил цалинг нэмэхийг шаардаж эхэлнэ. Ингээд ихэнх хүмүүс төрийн салбар руу явах хүсэл эрмэлзэлтэй болсноор Монгол улсын улс төржих процесс зогсохгүй юм.

Боловсрол, эрүүл мэндийн салбарын хүмүүсийн цалинг нэмэгдүүлэх талаар тавьж байгаа шаардлага нь

бодитой боловч бүгдийг нь нэмэхээсээ өмнө тооцоолол хийх шаардлагатай юм. Бид 200 мянга орчим хүний цалинг сар болгон нэмэхээр төсвийн ачаалал ихэснэ. Энэ тооцооллыг хэрхэн хийсэн, нөгөө талдаа зардлаа хаанаас хасах тухай хэн ч ярихгүй байгаа юм. Өөрөөр хэлбэл өртөг өгөөжийн талаас нь буюу энэ мөнгийг өөр зүйлд зарцуулаад юу өгөх вэ гэдэг талаас авч үзвэл ийм байгаа юм.

Эдийн засгийн өөр нэг аргаар буюу зориудын болон зориудын бус үр дагавар гарах уу гэдэг үүднээс харвал хувийн хэвшилд их сөрөг нөлөөлөл үзүүлэх магадлалтай. Өрсөлдөх чадварынх нь талаас авч үзвэл төрийн албан хаагчийн бүтээмжийг цалин хөлстэй нь уялдуулах, системийг боловсронгуй болгох шаардлага гарч байна. Мөн үүнд улс төрийн талаас авч үзвэл нэгдүгээрт төрийн албанд орж байвал юу ч хамаагүй гэдэг хожоо хайх боломж өсөх хандлагатай байна. Хоёрдугаарт төсвийн орлого төлөвлөсөн хэмжээнээс давсан бол цалингаа нэмэх үү эсхүл сургууль цэцэрлэгээ барих уу гэсэн асуулт гарч байгаа юм.

Төрийн алба гэдэг нэр томьёо өөрөө буруу нэр томьёо. Ардчилсан нийгэмд төрийн алба биш нийтийн алба гэж хэлдэг. Бидний сэтгэлгээнд төрийн төлөө гэдэг нь нийтийн төлөө гэдгээсээ илүү хүчтэй хэвээр байна. Төрд ажиллаж буй хүмүүсийн үндсэн үүрэг нь нийтийн сайн сайхны төлөө ажиллах ёстой болохоос төрийн өөрийнх нь сайн сайхны төлөө, төрийг хөгжүүлэхийн төлөө байх ёсгүй юм.

Сангийн сайд төсөвт тодотгол хийхгүй гэж амалсан. Ер нь төсвийн орлого төлөвлөснөөсөө их байгаа юм бол үүнийг цалин нэмэхэд зарцуулах уу, бүтээн байгуулалтад зарцуулах уу гэдгийг авч үзээгүй юм.

АМЬЖИРГААНЫ БАТАЛГААЖИХ ДООД ТҮВШИН ШИНЭЧЛЭГДЛЭЭ

Хүн амын амьжиргааны доод түвшин гэдэг нь хэрэглээний доод хэмжээг мөнгөн хэмжээгээр илэрхийлсэн илэрхийллийг хэлнэ гэж хуулиндаа заасан байдаг. Хүний нэн тэргүүний зайлшгүй хэрэгцээг хангах, хүнсний болон хүнсний бус хэрэглээний сагсаар тодорхойлно гэж заасан байдаг юм байна. Амьжиргааны баталгаажих доод түвшинг ихэсгэснээр хүн амын амьжиргаа дээшлэх үү гэсэн асуулт гарч ирж байгаа юм. Үгүй энэ бол доод хэмжээ юм. Доод хэмжээ буюу зайлшгүй байх ёстой хэмжээ учраас үүнийг дээш доошоогоо багасгах нь тэр айлыг сайхан амьдруулахгүй.

Судлаачид амьжиргааны баталгаажих доод түвшин

Region	Included province	Minimum standard of living in 2017 (MNT)	Minimum standard of living in 2018 (MNT)
Western	Bayan-Ulgii, Govi-Altai, Zavkhan, Uvs, and Khovd	166,500	178,000
Khangai Mountainous	Arkhangai, Bayankhongor, Bulgan, Uvurkhangai, Khuvsgul, and Orkhon	173,500	182,600
Central	Govisumber, Dornogovi, Dundgovi, Umnugovi, Selenge, Tuv, and Darkhan-Uul	166,200	175,600
Eastern	Dornod, Sukhbaatar, and Khentii	165,700	174,000
Ulaanbaatar	Ulaanbaatar	185,300	198,600

ядуурлыг бууруулахад бага нөлөөтэй гэж үздэг. Яагаад гэвэл амьжиргааны баталгаажих доод түвшинд цалин авдаг хүмүүс цөөхөн байдаг. Хоёрдугаарт, ажилгүй буюу ядуу хүнд энэ хамаардаггүй. Гуравдугаарт, ажилгүйдлийн

түвшинг нэмдэг гэж үздэг. Учир нь жижиг дунд үйлдвэр мэргэжилгүй хүнийг цагийн ажлаар авах нь үнэтэй болоод эхэлдэг. Нэгэнт үнэтэй болоод ирэхэд цалинтай хүнийг ажиллуулсан нь дээр гэж үзээд ажилд авдаггүй. Дөрөвдүгээрт, үнэ нэмэгддэг. Учир нь олгогч хүмүүст өгөх хөдөлмөрийн хөлс нэмэгдэхийн хэрээр ажил олгогчийн ашгийн түвшин багасдаг учир үнээ нэмдэг. Үнээ нэмэхэд хэрэглэгчид илүү их төлбөр төлдөг. Нөгөө талаас үнээ нэмэхгүйгээр ашиг багасна. Ашиг багассаар байгаад компани дампуурвал бүгд ажилгүй болно. Эдгээр үр дагавар үүснэ гэж үзэж байгаа.

Инфляцид тодорхой хэмжээгээр нөлөөлнө. Иймэрхүү бодлого нь Засгийн газрын бодлогыг унагахад хүргэдэг.

Өөрөөр хэлбэл үргэлж нэмээд байх боломжгүйд хүрч улмаар өр нэмэгдэж эхэлдэг. Өрнөөсөө болоод эдийн засгийн уналтанд ордог юм.

Өөр нэг асуулт буюу энэ нь ёс зүйтэй юу үгүй юу гэдэг асуултын хувьд энэ бол үргэлж ёс зүйтэй харагддаг. Гэвч үүнээсээ илүү энэ нь улс төрчдийн бодож олсон механизм юм.

Хамгийн сүүлийн асуулт буюу шударга уу үгүй юу гэдгийн хувьд бол халамжийн хувьд шударга бол хөдөлмөрийн хөлсний хувьд шударга бус юм.

СЭТГҮҮЛЧДИЙН НЭГДСЭН ЭВЛЭЛИЙН 17 ДУГААР ИХ ХУРАЛ БОЛЛОО

1951 онд анх байгуулагдахдаа тэр үеийн гол зорилго нь социализмыг мандуулах, МАХН-ын нэр төрийг үргэлж өндөрт авч явах байсан. Улмаар Монгол улсад хувьсгалт өөрчлөлт болж 1992 онд Монголын чөлөөт ардчилсан сэтгүүлийн эвлэл гэж байхдаа Ардчилсан хэсэг нь тасарч салсан юм. Ийнхүү 10 гаруй жил явсны дараа 2003 онд Ардчилсан сэтгүүлчдийн холбоо болон Монголын сэтгүүлчдийн холбоо хоёр нийлж Монголын нэгдсэн сэтгүүлчдийн эвлэл гэж байгуулагдсан юм байна. Ийнхүү 15 жилийн дараа буцаж салахдаа өмнөхөөсөө өөр зарчмаар салсан байна. Үүнээс үзвэл энэ байгууллага нь анхнаасаа намаас хараат байсныг дүрмэндээ намаас хараат бус гэж өөрчлөлт оруулсан байснаа буцаагаад өөрчилж хараат болгож байгаа юм.

Мөн үүнд ашиг сонирхлын зөрчил байгаа юм. Үг хэлэх эрх чөлөөтэй ч гэсэн зөвхөн өөрийнхөө ашиг сонирхлын төлөө үг хэлэх эрхтэй, түүнийгээ хамгаалах үндсэн зорилготой. Хоёрдугаарт, улс төрчид хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй. Монгол улсын Ерөнхийлөгч хүртэл өөрийн гэсэн телевизтэй. Монгол улсад улс төрчдөөс гадна банкууд нь хэвлэл мэдээллийн хэрэгсэлтэй байгаа.

Ингэхээр хэвлэл мэдээллийн хэрэгсэл чөлөөтэй байх боломжгүй болж байгаа юм. Энэ бүхний үр дүнд Монгол улсын авлига зогсохгүй байгааг тэмдэглэх нь зүйтэй. Ер нь бол иймэрхүү нөхцөлд монголын хэвлэл мэдээллийн хэрэгсэл хэзээ ч бүрэн эрх чөлөөтэй болохгүй байгаа юм. Эрх чөлөөгүй олон хүмүүсийн нэгдэлд ямар эрх чөлөө байх юм. Аль нэг улс төрийн намын нөлөөлөл илүү болоод байна. Эхлээд бүх түүхээрээ МАХН-ынх байсан. 1992 онд Ардчилсан намын талын хүмүүс болоод, буцаж холимог болж байгаад одоо МАН-руу шилжиж байна. Шинэ дарга Х.Мандахбаяр нь мянган сэтгүүлчийг орон сууцтай болгоно, эрсдлийн болон эрүүл мэндийн даатгалд сэтгүүлчдийг хамруулна гэж амлаад сонгогдож байгаа юм. Ийнхүү амлахдаа яаж энэ амлалтаа биелүүлэх талаараа хэлээгүй. Сэтгүүлчдийн амьдралыг сайжруулах үндсэн механизм бол тухайн хэвлэл мэдээллийн хэрэгслийн хараат бус байдал, өрсөлдөх чадвар, гаргаж байгаа мэдээллийн агуулгын чанар сайн байвал илүү анхаарал татна. Анхаарал татсан компанийн орлого нь өндөр байна. Энэ маягаар хөдөлмөрийн бүтээмжээрээ өрсөлдөх ёстой.

ҮЙЛДВЭРЖИЛТИЙГ ДЭМЖИХ 21:100 ХӨТӨЛБӨР БАТЛАГДЛАА

Ер нь бол төр засгийг амласнаар нь бус хийснээр нь дүгнэх ёстой. Санаа нь бол сайхан, гэхдээ боломжгүй. Яагаад гэвэл энэ бүхнийг авлига оролцохгүйгээр хийх чадвар монголын төр засагт байхгүй болсон. Хувийн компаниудыг сонгон шалгаруулах зарчим нь хуурамч, ил тод биш байгаа юм. Жижиг дунд үйлдвэрийн санд хэдэн төгрөг байгааг бид мэдмээр байна, яаж шалгаруулалт болдгийг бид мэдмээр байна. Хөндлөнгийн аудитын дүгнэлт, тайланг бид хармаар байна.

Би 2010 онд Чили улсад очсон. Манайх шиг уул уурхайгаас хамааралтай энэ улсын хувьд өөрийн өрсөлдөх 5 салбарыг сонгож авсан. Тэгээд Чили сан гэж ТББ байгуулаад төртэйгээ хамтарч бүх зүйлээ ил тод болгож байгаад тэр 5 салбарыг хөл дээр нь босгоход хөрөнгө оруулалт хийсэн. Загас, дарс, жимс, ногоо, мод гэх 5 салбараар аж ахуй байгуулаад энэхүү байгууллагаар дамжуулан бусдадаа зааж өгөөд түүнийгээ хувьцаат компани болгоод

хувьчилчихсан юм. Би энэ тухай 2010 онд *Санхэмтэн* гэдэг нийтлэл бичсэн. ТББ нь хянаж, ил тод болгох ажлыг төртэй хамтраад хийхээр ийм үр өгөөж гардаг юм. Харин төр аль нэг компанитай хамтрахаар бидний мөнгө усанд хаясан чулуу шиг алга болчихоод байна.

Дефакто тоймын гол агуулгыг хураангуйлан бэлтгэв.

Тоймын бүрэн эхийг <http://jargaldefacto.com/article/defakto-toim-2sh18-sh2-11> холбоосоор үзнэ үү



NEW NISSAN PATROL

9911-0014, 9911-5140, 9910-0167

ЛИЗИНГИЙН НӨХЦӨЛ:

Урьдчилгаа **0%**

Хүү **1.4%**

Хугацаа **84** сар

УРАМШУУЛАЛ:


-  Хамгаалалтын хууцаг
-  Сэлбэг сервисын эрх
-  4x4 Өвлийн дугуй
-  Салонь шигшнэй хамгаалалт

ҮНЭ: ₮214.0 сая

JARGAL DEFAC TO

ГАР УТАСНЫ АППЛИКЭЙШН

The Defacto Gazette



Та “Дефакто Газет” цахим сонинг төлбөргүй тогтмол хүлээн авахыг хүсвэл
www.jargaldefacto.com болон www.defacto.mn вебсайтад өөрийн имейлээ бүртгүүлнэ.

РЕДАКЦЫН ЗӨВЛӨЛ

Дамбадаржаагийн Жаргалсайхан
Дангаасүрэнгийн Энхбат

ГҮЙЦЭТГЭЛИЙН БАГ

Ерөнхий редактор: Ганбаатарын Жавзмаа
Баг: Батхүүгийн Амар
Отгонсүрэнгийн Билгүүн
Өсөхбаярын Биндэръяа
Адъяагийн Тунгалаг
Нямаагийн Цэнгэл

ХОЛБОО БАРИХ

✉ editor1@jargaldefacto.com
☎ +976 94109342
🌐 www.defacto.mn